

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Дэвжих Капитал аудит ХХК-ийн захирал : Л.Отгон Утас: 99059489 Цахим хаяг: <a href="mailto:devjikhcapital.audit@gmail.com">devjikhcapital.audit@gmail.com</a> Аудитор: Ц.Базарсад Утас: 99065336 Цахим хаяг: <a href="mailto:bazka0330@gmail.com">bazka0330@gmail.com</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 7048-4030,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02.24

№

86

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөхморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллагын улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 6,774.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилт 28,893.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд Орон нутгийн Өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 369 дүгээр албан тоотыг үндэслэн 26,356.7 мянган төгрөгийн элэгдлээрээ өртөгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийн үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтоосон байна.

**Бусад асуудал**

Тайлант онд 1 хөтөлбөр, 6 зорилт, 84 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 78 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 6 арга хэмжээг дутуу

ХӨХМОРЬТ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
П.ЧАНЦАЛНЯМ ТАНАА

822505000232

хэрэгжүүлж, биелэлтийг 92.9 хувиар үнэлж хүргүүлсэн бөгөөд аймгийн Боловсролын газраас 83.0 хувиар "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



**Нэг. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>170,397,442.65</b>	<b>114,174,585.15</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>123,464,458.12</b>	<b>63,976,567.99</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>123,464,458.12</b>	<b>63,976,567.99</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>123,464,458.12</b>	<b>63,976,567.99</b>
<b>31211</b>	Төрийн сангийн харилцах	123,464,458.12	63,976,567.99
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>254,037.53</b>	<b>660,970.16</b>
<b>33100</b>	Ажиллагчидтай холбогдсон авлага	254,037.53	660,970.16
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>46,678,947.00</b>	<b>49,537,047.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>46,678,947.00</b>	<b>49,537,047.00</b>
<b>35410</b>	Бичиг хэргийн материал	3,367,500.00	3,365,500.00
<b>35420</b>	Аж ахуйн материал	29,832,997.00	30,562,597.00
<b>35430</b>	Сэлбэг хэрэгсэл	760,000.00	760,000.00
<b>35440</b>	Түлш, шатах тослох материал	900,000.00	-
<b>35460</b>	Хүнсний материал	943,450.00	3,973,950.00
<b>35470</b>	Бусад хангамжийн материал	10,875,000.00	10,875,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>385,083,279.76</b>	<b>379,932,825.51</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>385,083,279.76</b>	<b>379,932,825.51</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>381,741,279.76</b>	<b>376,590,825.51</b>
<b>39201</b>	Барилга, байгууламж, орон сууц	455,695,929.93	455,695,929.93
<b>39202</b>	Хуримтлагдсан элэгдэл	(121,487,984.52)	(144,869,315.28)
<b>39205</b>	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,506,470.00	18,906,470.00
<b>39206</b>	Хуримтлагдсан элэгдэл	(8,508,392.78)	(9,498,287.38)
<b>39207</b>	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,325,504.00	61,325,504.00
<b>39208</b>	Хуримтлагдсан элэгдэл	(51,721,826.87)	(32,901,055.76)
<b>39214</b>	Бусад үндсэн хөрөнгө	27,931,580.00	27,931,580.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>3,342,000.00</b>	<b>3,342,000.00</b>
<b>39301</b>	Програм хангамж	300,000.00	300,000.00
<b>39302</b>	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(300,000.00)
<b>39303</b>	Бусад биет бус хөрөнгө	3,342,000.00	3,342,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>555,480,722.41</b>	<b>494,107,410.66</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,806,200.00</b>	<b>356,500.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,806,200.00</b>	<b>356,500.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>1,806,200.00</b>	<b>356,500.00</b>
<b>41320</b>	Бараа үйлчилгээний зардлын өглөг	366,400.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,439,800.00</b>	<b>356,500.00</b>
<b>41361</b>	Байгууллагад төлөх өглөг	1,439,800.00	356,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>553,674,522.41</b>	<b>493,750,910.66</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>553,674,522.41</b>	<b>493,750,910.66</b>
<b>511</b>	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	90,429,947.00	90,429,947.00
<b>51101</b>	Өмч: - төрийн	90,429,947.00	90,429,947.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>15,988,589.06</b>	<b>29,708,295.31</b>
<b>51210</b>	Өмнөх үеийн үр дүн	61,896,538.43	115,988,589.06
<b>51220</b>	Тайлант үеийн үр дүн	54,092,050.63	(86,280,293.75)
<b>51300</b>	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	347,255,986.35	373,612,668.35
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>555,480,722.41</b>	<b>494,107,410.66</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>675,929,500.00</b>	<b>698,959,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,780,000.00</b>	<b>1,141,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	13,780,000.00	1,141,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,780,000.00	400,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	10,000,000.00	706,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>662,149,500.00</b>	<b>697,817,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	604,850,100.00	611,624,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	604,850,100.00	611,624,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	57,299,400.00	86,193,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,299,400.00	86,193,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>620,837,449.37</b>	<b>785,239,593.75</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>620,837,449.37</b>	<b>785,239,593.75</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	617,109,200.87	764,829,759.48
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	415,741,219.51	528,001,170.50
210101	Үндсэн цалин	284,357,250.81	337,212,782.23
210102	Нэмэгдэл	115,480,430.80	164,603,465.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,090,000.00
210104	Урамшуулал	15,903,537.90	24,094,923.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,353,592.40	65,143,500.00
210201	Тэтгэврийн даатгал	35,483,899.96	44,300,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,121,591.06	5,212,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,338,061.69	2,606,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,060,745.59	2,606,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,349,294.10	10,417,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	52,037,551.50	68,671,062.73
210301	Гэрэл, цахилгаан	4,071,151.50	5,201,262.73
210302	Түлш, халаалт	47,966,400.00	63,469,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	48,413,450.00	49,294,750.00
210502	Хоол, хүнс	48,413,450.00	49,294,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	645,000.00	2,005,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	645,000.00	2,005,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	46,918,387.46	51,713,876.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,286,800.00	15,160,740.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,229,000.00	4,646,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,402,587.46	31,907,136.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,728,248.50	20,409,834.27
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	3,684,197.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,684,197.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	3,728,248.50	16,725,637.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,728,248.50	16,725,637.27
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>55,092,050.63</b>	<b>(86,280,293.75)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,000,000.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,000,000.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(1,000,000.00)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>54,092,050.63</b>	<b>(86,280,293.75)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>662,149,500.00</b>	<b>697,852,700.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>662,149,500.00</b>	<b>697,817,700.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	604,850,100.00	611,624,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	604,850,100.00	611,624,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,299,400.00	86,193,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,299,400.00	86,193,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>590,816,412.91</b>	<b>757,340,590.13</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	590,816,412.91	757,340,590.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	587,088,164.41	736,930,755.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	415,741,220.51	527,747,132.97
210101	Үндсэн цалин	284,357,250.81	337,212,782.23
210102	Нэмэгдэл	115,480,430.80	164,349,427.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1.00	2,090,000.00
210104	Урамшуулал	15,903,537.90	24,094,923.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,353,592.40	65,804,470.16
210201	Тэтгэврийн даатгал	35,483,899.96	44,954,789.36
210202	Тэтгэмжийн даатгал	4,121,591.06	5,215,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,338,061.69	2,607,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,060,745.59	2,607,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,349,294.10	10,419,080.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,571,151.50	69,467,462.73
210301	Гэрэл, цахилгаан	3,704,751.50	5,567,662.73
210302	Түлш, халаалт	48,866,400.00	63,899,800.00
2105	Нормативт зардал	46,649,400.00	51,413,100.00
210502	Хоол, хүнс	46,649,400.00	51,413,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	645,000.00	2,005,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	645,000.00	2,005,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,127,800.00	20,493,190.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,253,800.00	15,847,190.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,874,000.00	4,646,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,728,248.50	20,409,834.27
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,728,248.50	16,725,637.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,728,248.50	16,725,637.27
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>71,333,087.09</b>	<b>(59,487,890.13)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>71,333,087.09</b>	<b>(59,487,890.13)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	52,131,370.03	123,464,458.12
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	123,464,458.12	63,976,567.99

Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	90,429,947.00	347,255,986.35	61,896,538.43	499,582,471.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,429,947.00	347,255,986.35	61,896,538.43	499,582,471.78
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	54,092,050.63	54,092,050.63
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,429,947.00	347,255,986.35	115,988,589.06	553,674,522.41
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	90,429,947.00	347,255,986.35	115,988,589.06	553,674,522.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,429,947.00	347,255,986.35	115,988,589.06	553,674,522.41
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	26,356,682.00	-	26,356,682.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(86,280,293.75)	(86,280,293.75)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,429,947.00	373,612,668.35	29,708,295.31	493,750,910.66

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт Хэмнэлт	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	787,416,800.00	740,614,952.86	46,801,847.14	106.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	787,416,800.00	740,614,952.86	46,801,847.14	106.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	783,732,600.00	736,930,755.86	46,801,844.14	106.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	551,803,500.00	527,747,132.97	24,056,367.03	104.56
210101	Үндсэн цалин	349,254,100.00	337,212,782.23	12,041,317.77	103.57
210102	Нэмэгдэл	187,403,100.00	164,349,427.74	23,053,672.26	114.03
210104	Урамшуулал	15,146,300.00	24,094,923.00	(8,948,623.00)	62.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,697,900.00	65,804,470.16	2,893,429.84	104.40
210201	Тэтгэврийн даатгал	46,625,700.00	44,954,789.36	1,670,910.64	103.72
210202	Тэтгэмжийн даатгал	5,518,000.00	5,215,000.00	303,000.00	105.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,759,000.00	2,607,800.00	151,200.00	105.80
210204	Ажилгүйдлийн даатгал	2,759,000.00	2,607,800.00	151,200.00	105.80
210205	Эрүүл мэндийн даатгал	11,036,200.00	10,419,080.80	617,119.20	105.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,193,100.00	69,467,462.73	16,725,637.27	124.08

Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	5,567,662.73	432,337.27	107.77
210302	Түлш, халаалт	79,693,100.00	63,899,800.00	15,793,300.00	124.72
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	-	500,000.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>52,432,200.00</b>	<b>51,413,100.00</b>	<b>1,019,100.00</b>	<b>101.98</b>
210502	Хоол, хүнс	52,432,200.00	51,413,100.00	1,019,100.00	101.98
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,729,900.00</b>	<b>2,005,400.00</b>	<b>724,500.00</b>	<b>136.13</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,729,900.00	2,005,400.00	724,500.00	136.13
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,876,000.00</b>	<b>20,493,190.00</b>	<b>1,382,810.00</b>	<b>106.75</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,204,700.00	15,847,190.00	1,357,510.00	108.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,671,300.00	4,646,000.00	25,300.00	100.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,684,200.00</b>	<b>3,684,197.00</b>	<b>3.00</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,684,200.00</b>	<b>3,684,197.00</b>	<b>3.00</b>	<b>100.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,684,200.00	3,684,197.00	3.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>787,416,800.00</b>	<b>740,614,952.83</b>	<b>46,801,847.17</b>	<b>106.32</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>612,086,600.00</b>	<b>611,624,600.00</b>	<b>462,000.00</b>	<b>100.08</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	612,086,600.00	611,624,600.00	462,000.00	100.08
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>86,193,100.00</b>	<b>69,467,462.70</b>	<b>16,725,637.30</b>	<b>124.08</b>
132001	Орон нутгийн төсвөөс	86,193,100.00	69,462.70	16,725,637.30	124.08
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>89,137,100.00</b>	<b>59,522,890.13</b>	<b>29,614,209.87</b>	<b>149.75</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	35,000.00	35,000.00	-	100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	89,102,100.00	59,487,890.13	29,614,209.87	149.78

### ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулагдаагүй 10,056.7 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар 10,056.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 792.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 9,264.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

#### 3.1 Төлбөрийн акт

Хүүхдийн ирцийн мэдээгээр 5,9,10 саруудад хүүхдийг ирсэн тоогоор бус тогтмол 97 гэж бүртгэснээс хоолны менюгээс 792.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.  
төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Нэг. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 15,513.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид унаа хоолны хөнгөлөлтийг төсвийн төсөлд тусган, баталсан төсвийн хүрээнд зарцуулах.

#### Хоёр. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт тусгагдаагүй архив, бичиг хэргийн албан тушаалын ажил хавсруулж, 6,236.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг хүрээнд албан хаагчдад ажил хавсран гүйцэтгэх цалингийн зардлыг төсөвт тусгуулан, батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах

#### Гурав. Нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарттай холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд 3,028.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудас анхан шатны баримт бүрдэл дутуу хөтөлж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын	Хүүхдийн ирцийн мэдээгээр 5,9,10 саруудад хүүхдийг ирсэн тоогоор бус тогтмол 97 гэж бүртгэснээс хоолны менюгээс 792.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан	1	792.0	1	792.0							
	Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн тушаалаар өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 15,513.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-
Хүүхдийн цэцэрлэг	Батлагдсан төсөвт тусгагдаагүй архив, бичиг хэргийн албан тушаалын ажил хавсруулж, 6,236.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна.	1	6,236.0	-	-	-	-	1	6,236.0	-	-	
	Тайлант онд 3,028.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудас анхан шатны баримт бүрдэл дутуу хөтөлж зарцуулсан	1	3,028.7						1	3,028.7		
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>10,056.7</b>	<b>1</b>	<b>792.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>9,264.7</b>	<b>-</b>	<b>-</b>	



**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			